

УКРАИНЫ ТЭТГЭЛЭГ

Украины бакалаврын тэтгэлэгт хөтөлбөрт жил бүр тодорхой тооны монгол иргэдийг тэтгэлгийн тоонд багтаан шалгаруулж авдаг. Тиймээс элсэх оюутны тоо жил бүр өөр байж болно.

Бакалаврын тэтгэлэгт хөтөлбөр: Жил бүрийн 1-2-р сард

Жил бүр хомстолд ордог ажлын байрны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн суралцах чиглэлийг зарладаг.

Мэргэжлийн сургалтын чиглэл:

- Нисэхийн инженер
- Замын инженер
- Төмөр замын инженер
- Зам тээврийн зохион байгуулалт
- Анагаах ухаан

Тэтгэлгийн хугацаа: 4 жил

Тавигдах шаардлага:

1. Өргөдөл гаргагч нь 21 нас хүрээгүй Монгол Улсын иргэн байх ёстой.
2. ЕБС-ийн дипломын дундаж үнэлгээ 80-аас дээш байх ба их, дээд сургуулийн 1 эсвэл 2-р дамжааны оюутан бол 3.0 ба түүнээс дээш дүнгийн голч оноотой байх ёстой.
3. Өмнө нь аль ч улсын засгийн газрын тэтгэлэгт хамрагдаж байгаагүй байх.
4. Орос хэлний бэлтгэлд бүрэн бэлтгэгдсэн, орос хэлний гүнзгийрүүлсэн сургалттай, Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургуулийг 80-аас дээш хувийн дундаж дүнтэй төгссөн байх.

Сонгон шалгаруулах үйл явц:

- Цахим өргөдөл (www.esis.edu.mn/grant хаягаар орж, цахим анкет бөглөж, бичиг баримтаа өргөдөлдөө байршуулна)
- Бакалаврын зэрэг олгох тэтгэлэгт хамрагдагсдын сонгон шалгаруулалтыг бичгийн шалгалт, ярилцлагын хэлбэрээр явуулна.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас тэтгэлэгт тэнцсэн оюутнуудыг холбогдох Засгийн газраас нэр дэвшүүлнэ.
- Нэр дэвшигчийн боловсролын талаарх эцсийн шийдвэрийг хүлээн авагч тал гаргана. Засгийн газрын тэтгэлэгт сургалтын төлбөр болон амьжиргааны тэтгэлэг багтдаг. Бусад зардлыг (аяллын зардал, эрүүл мэндийн даатгал гэх мэт) оюутан өөрөө хариуцна.
- Дэлгэрэнгүй мэдээллийг БСШУСЯ-ны www.mecs.gov.mn цахим хуудасны Гадаадад суралцах хэсгээс авна уу.